



**ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/75

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.4, 16.16 дахь заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.2, 8 дугаар зүйл 8.1 дэх заалт, Төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 6330:2017, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 5.3, Төвийн хөдөлмөрийн дотоод журмын 3.2.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Халдварт өвчин судлалын үндэсний төвд үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх үйл ажиллагааны журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Халдварт өвчин судлалын үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчийн сахиурын журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

2. Энэхүү журмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй нийт эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд танилцуулахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч (Ж.Ариунбилэг)-т, хэрэгжүүлэн ажиллахыг нийт алба тасгийн дарга, эрхлэгч нарт, төвийн тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын албаны даргын үүргийг түр хавсран гүйцэтгэгч (Б.Энхжаргал)-д болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ц.БИЛЭГТСАЙХАН

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын
2023 оны 4 дүгээр сарын 15-ний өдрийн
1/75 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Тус төвөөс үйлчлүүлэгчид үзүүлж байгаа эмнэлгийн тусламж үйлчилгээг чанар, хүртээмжтэй үзүүлэх, хяналт тавих, тусламж үйлчилгээг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг тодорхой болгох нь энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Уг журам нь ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцооны стандартын шаардлагад нийцсэн болно.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1.Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвд үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэхтэй холбогдсон харилцааны бүх оролцогчдод хамаарч үйлчилнэ.

ГУРАВ.ҮЙЛ ЯВЦ:

- 3.1 Үйлчлүүлэгчийг яаралтай тусламжийн тасаг, амбулатори, бусад эмчилгээний тасгаас хэвтүүлэх эмчлүүлэх тасгийн ээлжийн сувилагч, туслах сувилагч хүлээн авч хуваарьт өрөөнд оруулна.
- 3.2 Сувилагч үйлчлүүлэгчийн амин үзүүлэлтийг үзэж сувилгааны маягт бөглөнө. Ажлын цагаар тасгийн эрхлэгч эмчид, ажлын бус цагаар тухайн тасгийн жижүүр эмчид мэдэгдэнэ.
- 3.3 Эмч эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу үзлэг хийн эмчилгээг зөвлөнө. Шаардлагатай тохиолдолд онош тодруулах шинжилгээ оношилгоонд хамруулна.
- 3.4 Оношилгоо, шинжилгээний дүгнэлтийг үндэслэн тасгийн эрхлэгч эмч, бусад нарийн мэргэжлийн эмч , зөвлөх эмч нарын зөвлөгөө авна, хамтарсан дүгнэлт гарган эмийн эмчилгээ төлөвлөнө.
- 3.5 Шинжилгээний дүгнэлт өөрчлөлтгүй бол эмчилгээг хэвээр үргэлжлүүлнэ.
- 3.6 Тасгийн сувилагч эмийн түүврийг хийнэ.

3.7 Цахим программд СТ1 ,СТ2-ийн дагуу эмийн захиалга хийнэ.

3.8 Эм зүйч ЭМС-ын 2009 оны 388 тоот тушаалын дагуу эмийн бүртгэл хийнэ.

3.9 Эм зүйч цахим өвчний түүхийн түүврийн дагуу үйлчлүүлэгчид эмийн эмчилгээг олгоно.

3.10 Тасгийн сувилагч үйлчлүүлэгчид олгосон эмчилгээг эмчийн зааврын дагуу хийнэ.

3.11 Сувилагч эмийн болон эмийн бус эмчилгээг хийн цахим программд СТ1, СТ2-ийн дагуу хөтөлнө.

3.12 Эмч нарын хамтарсан үзлэгийн дүгнэлтээр нэмэлт шинжилгээ хийх шаардлагатай бол зөвлөх эмч , бусад нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө аван дүгнэлт гаргана .

3.13 Үндсэн эмчилгээ хийснээр биеийн байдлыг сайжирсан бол үнэлж , зөвлөгөө өгч, эмнэлгээс гаргана.

3.14 Биеийн байдал сайжраагүй бол нэмэлт шинжилгээ, эмч нарын хамтарсан үзлэг хийж, ЭМС-ын 2021 оны А/813 тоот тушаал болон байгууллагын үйлчлүүлэгч шилжүүлэх журмын дагуу бусад тасагт шилжүүлэх, бусад эмнэлэгт шилжүүлэх шийдвэр гаргана.

ДӨРӨВ.ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ.

4.1 Үйлчлүүлэгч өөрийнхөө болон гэр бүлийнхээ эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх;

4.2 Эрүүл мэндийн байгууллагын ажилтантай хүндэтгэлтэй харилцаж, соёлтой үйлчлүүлэх;

4.3 Байгууллагын дотоод дүрэм, журмыг дагаж мөрдөх ;


4.4 Эмчилгээ үйлчилгээний заавар дэглэмийг чанд сахих ;

4.5 Бусдын эрхийг хүндэтгэх;

4.6 Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байхад зураг авах болон дуу, дүрс бичлэг хийхгүй байх;

4.7 Өөрийн болон асран хамгаалж буй үйлчлүүлэгчийн биеийн байдал, эрүүл мэндийн талаарх мэдээллээ эмнэлгийн мэргэжилтэнд үнэн зөв бүрэн мэдээлэх үүрэг хүлээнэ.

4.8 Өөрийн эд хөрөнгийг (үнэт эдлэл, гар утас гэх мэт) хэвтэн эмчлүүлэгч өөрөө хариуцна. Алдагдсан тохиолдолд байгууллага хариуцахгүй



ТАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ

5.1 Үйлчлүүлэгч нь эрүүл мэндийн чанартай, тэгш хүртээмжтэй тусламж, үйлчилгээг авах;

5.2 Биеийн эрүүл мэндийн байдал болон эмчилгээ, үйлчилгээний үр дүн, өвчний явц, цаашид хийх эмчилгээ, гарч болох үр дагаврын талаар мэдээлэл авч, эмнэлгийн мэргэжилтэнтэй харилцан ярилцах, тайлбар авах;

5.3 Өөрийн эрүүл мэндийн талаарх нууцаа хамгаалуулах;

5.4 Эмчээ сонгон эмчлүүлэх, тусламж үйлчилгээний явцад эмчлэгч эмчээ солих санал тавих эрх эдэлнэ.

ЗУРГАА.ЭРГЭЛТИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

6.1 Эргэлтийг өдөр бүр 14:00-18:00 цагийн хооронд. Жич: Шинээр хэвтсэн эмчлүүлэгчийн эргэлтийг ирсэн тухайн үед нь оруулна.

ДОЛОО. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН БАРИМТЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ

- Үйлчлүүлэгч 8:00 цагт босон эмчийн үзлэгт бэлдэнэ.
- 9:00 цагт өглөөний цай
- Эмчийн үзлэг
- Эмчилгээндд орох
- 11:00 бага үдийн цай
- 13:00 цагт үдийн хоол
- 15:00 цагт их үдийн цай
- 18 :00 цагт оройн хоолны цаг
- 22:00 цагт унтах

НАЙМ. ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

8.1 Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, яаралтай тусламжийн эмч, түргэн тусламжийн эмч, резидент эмч, сувилагч, дуудлага зохицуулагч, түргэн

тусламжийн жолооч нар холбогдох бусад мэргэжилтнүүд энэ журмыг дагаж мөрдөнө

8.2 Төвд хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгч болон түүнтэй уулзах, эргэлт хийх иргэн энэ журмын холбогдох хэм хэмжээг дагаж мөрдөх үүрэгтэй.

8.3 Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирал, чанарын албаны дарга, менежер, тасгийн эрхлэгч нар энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

ЕС. ЖУРАМ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

9.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын
2023 оны 1 дүгээр сарын 15-ний өдрийн
1/75 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧИЙН САХИУРЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь халдварт өвчнөөр өвчилж, тус төвд хэвтэн эмчлүүлж байгаа бага насны хүүхэд, байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настныг асарч сувилах, байнга хянах, ахуйн ослоос сэргийлэх зорилгоор асран хамгаалах иргэний / цаашид Сахиур гэх/ эрх зүйн байдлыг тогтоох, үйл ажиллагааг журамлан зохицуулахад чиглэгдэнэ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Энэ журмыг үйлчлүүлэгчийн хэвтэн эмчлэх үйл ажиллагааг явуулж байгаа төв, тасаг, ажилтан болон эмчлүүлэгчийг асран хамгаалж буй сахиурт хамаарч үйлчилнэ.

ГУРАВ. САХИУРТАЙ ЭМЧЛҮҮЛЭХ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, САХИУРЫГ ЗӨВШӨӨРӨХ

3.1. Тус төвд хэвтэн эмчлүүлэх доорх үйлчлүүлэгч сахиуртай байна:

3.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй өөртөө үйлчлэх чадваргүй, байнгын асаргаанд байдаг хүн

3.1.2. Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгч

3.1.3. Долоо ба түүнээс доош насны хүүхэд

3.1.4. Өвчний улмаас бусдын асаргаа, сувилгаа зайлшгүй асаргаа, сувилгаа шаардлагатай эмчлүүлэгч

3.2. Хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчийг сахиуртай байх эсэхийг эмчлэгч эмч шийдвэрлэнэ.

3.3. Эмнэлэгт хэвтэх хугацаанд сахиурыг солихгүй, эмнэлгээс гарах хүртэл сахина.

3.4. Эмнэлэгт эмчлүүлж буй өвчтөнд сахиур зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн эмчлэгч эмч нь тасгийн эрхлэгч, Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захиралд танилцуулан ар гэрээс нь сахиур хийх хүнийг дуудна.

3.5. Эрчимт эмчилгээний тасагт байгаа нэн хүнд өвчтөнд байнгын сахиур шаардлагагүй бөгөөд өвчтөний ар гэрийг зайлшгүй оруулах шаардлагатай үед

халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан нэг удаагийн хамгаалах хувцас өмсгөн оруулна.

ДӨРӨВ.САХИУРЫН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

4.1.Сахиурын эрх

4.2.Сахиурын үүрэг

4.2.1.Тус эмнэлэгт мөрдөгдөж буй эмнэлгийн дотоод журам, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтална.

4.2.2.Эмч, сувилагч, асрагч нарын өгсөн өгсөн зөвлөмж, үүргийг биелүүлнэ.

4.2.3.Гараа тогтмол угааж, ариун цэврийн өрөөнд орсон, олон нийтийн хүрэлцдэг гадаргууд хүрсэн тохиолдолд гарыг халдваргүйжүүлнэ.

4.2.4.Халдвартай бүсэд орохоос өмнө халдвар хамгааллын дэглэмийн талаар халдвар судлаач эмч, тасгийн эмч, сувилагчтай уулзаж зөвлөмж авна.

4.2.5.Сахиур нь хувийн ариун цэврийн хэрэгсэл оо, сойз, нойлын цаас, аяга, таваг, халбага, сэрээ, солих хувцас, амны хаалт зэрэг бэлэн байдлаа хангасан байна.

4.2.6.Сахиур эргэлтийн цагийн хуваарийг баримтална.

4.3.Сахиурын үйл ажиллагаанд доорх зүйлийг хориглоно.

4.3.1.Тамхи татах, архи уух;

4.3.2.Эмнэлгийн орчинд цэр, нус, цэрээ ил хаях;

4.3.3.Ахуйн зориулалттай цахилгаан хэрэгсэл хэрэглэх;

4.3.4.Эмнэлгийн ажилтнууд болон бусад иргэнтэй хэрүүл маргаан, зодоон үүсгэх.

ТАВ. ЖУРМЫГ ДАГАЖ МӨРДӨХ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

5.1.Энэ журмыг төвийн холбогдох ажилтан болон эмчлүүлэгчийн сахиур дагаж мөрдөнө.

5.2. Журмын хэрэгжилтэд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, тасгийн эрхлэгч, ахлах сувилагч хяналт тавина.

ЗУРГАА. ЖУРАМ ЗӨРЧИГЧИД ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

6.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.